



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 11590

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 20 дугаар
цэцэрлэгийн эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 185,400.0 /нэг зуун наян таван мянга дөрвөн зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн 20 дугаар цэцэрлэг /Д.Мөнхзаяа/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн 20 дугаар цэцэрлэг /Д.Мөнхзаяа/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.


ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115050001597

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2019 оны 12...дугаар
 сарын 12-өдрийн 1/390 тоот тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн 20 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХХК-ын хурлын шийдвэр
Бусад үндсэн хөрөнгө										
1	Нүүрсний амбаар	8	ш	1	185,400.00	185,400.00	185,400.00	-	Цаашид ашиглагдахгүй, хугацаа дууссан, өмхөрч муудсан.	татах
Бусад үндсэн хөрөнгийн дүн				1		185,400.00	185,400.00	-		
Нийт дүн				1		185,400.00	185,400.00	-		
Үүнээс: Худалдах хөрөнгө										
Актлах хөрөнгө										
Татан төвлөрүүлэх хөрөнгө					185,400.00					
Худалдсанаас олох орлого										
НӨАУГ-т төвлөрүүлэх /30%/										